



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 12 сарын 08 өдөр

Дугаар А/205

Улаанбаатар хот

**Зудын эрсдэлийн үнэлгээ хийх
Шуурхай бүлэг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 286 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт, 2020 оны 190 дүгээр тогтоолын 3.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.1 дэх заалт, Монгол Улсын Шадар Сайдын 2024 оны 103 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Багахангай дүүргийн үйлчлэх хүрээний нутаг дэвсгэрийн өвөлжилтийн бэлтгэл ажлын явц “Зудын эрсдэлийн үнэлгээ хийх” урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах ажлыг 2024 оны 12 дугаар сарын 09, 10-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2.Шуурхай бүлгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, шаардагдах төсвийг хоёр дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн сөрөг үр дагаварыг бууруулахад чиглэсэн “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” хөтөлбөрийн хэрэгжилттэй холбогдуулан малчдын санал хүсэлтийг авч, зээлийн зарцуулалт, төсөл хөтөлбөрийн үр дүнг дүгнэх, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулахыг шуурхай бүлгийн ахлагч, дүүргийн менежер (Г.Дагвадорж), Онцгой байдлын хэлтэс (хурандаа Б.Цогбадрах) нарт үүрэг болгосугай.

4.Шуурхай бүлгийн хоол, шатахууны зардалд шаардлагатай 1,014,360 (нэг сая арван дөрвөн мянга гурван зуун жар) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.


5.Үйл ажиллагааны үр дүнг танилцуулж ажиллахыг дүүргийн Онцгой комиссын орлогч, Онцгой байдлын хэлтэс (хурандаа Б.Цогбадрах)-т, захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 8 дугаар сарын 28 ны өдрийн
8 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



ШУУРХАЙ БҮЛГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

№	Чиг үүрэг	Овог, нэр	Байгууллага, албан тушаал
Нэгдүгээр бүлэг			
1.	Багийн ахлагч	Б.Цогбадрах	Онцгой байдлын хэлтсийн дарга, хурандаа
2.	Багийн нарийн бичиг	Д.Алтантогос	Хөдөө аж ахуйн тасгийн даргын үүрэг гүйцэтгэгч
3.	Багийн гишүүн	Н.Нямзав	Нэгдүгээр хорооны Засаг дарга
4.		А.Отгонжаргал	Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсийн мэргэжилтэн
5.		Б.Мөнх-Эрдэнэ	Онцгой байдлын хэлтсийн ГТУА 80 дугаар ангийн салааны захирагч, дэслэгч
6.	Жолооч	Г.Дэлгэрцогт	ОБХ-ийн ГУАМ-ны жолооч
Хоёрдугаар бүлэг			
7.	Багийн ахлагч	Г.Дагвадорж	Дүүргийн менежер
8.	Багийн нарийн бичиг	Х.Дуламсүрэн	Онцгой байдлын хэлтсийн мэргэжилтэн, дэслэгч
9.	Багийн гишүүн	Б.Батзориг	Хоёрдугаар хорооны Засаг дарга
10.		Д.Шүрэн-Эрдэнэ	Мал эмнэлгийн тасгийн дарга
11.		А.Пүрэвдорж	Улсын бүртгэлийн хэлтсийн мэргэжилтэн
12.	Жолооч	А.Үүрцайх	Засаг даргын тамгын газар

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 12 дугаар сарын 08 ны өдрийн
дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт



ТҮЛШ ШАТАХУУНЫ ТӨСӨВ

№	Явах чиглэл	Шатахуун	100 км-д	Нийт км	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1.	1-р хороо	Түлш	18 л	800	2390	344,160
2.	2-р хороо	Түлш	18 л	1000	2390	430,200
Нийт						774,360

ШУУРХАЙ БҮЛГИЙН ХООЛНЫ МӨНГӨНИЙ ТӨСӨВ

№	Хүний тоо	Нэг өдрийн хоолны мөнгө	Нийт хоног	Нийт хоолны мөнгө
1.	12	10,000	2	240,000
Нийт				240,000
Бүгд				1,014,360